



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/90/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Б.Нямдорж Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com</p>	
---	---	--


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28 № 147

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр тавилга бэлтгэсэн, тээвэр шатахуун зардлын тооцоолол хийгээгүй, спидометрийн заалтгүй, хийгдсэн ажил нь тодорхойгүй, барилгын урсгал засварыг капиталжуулаагүй, татварын тодорхойлолтоор зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй зэрэг 69.8 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, 14.4 дэх заалт, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07020286

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	49,916,915.92	64,539,785.92
33	АВЛАГА	1,882,000.00	1,882,000.00
33500	Бусад авлага	1,882,000.00	1,882,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,882,000.00	1,882,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,034,915.92	62,657,785.92
35100	Түүхий эд материал	1,768,300.00	1,768,300.00
35110	Тусгай зориулалттай материал	1,768,300.00	1,768,300.00
35400	Хангамжийн материал	46,266,615.92	60,889,485.92
35410	Бичиг хэргийн материал	462,000.00	511,500.00
35420	Аж ахуйн материал	2,864,628.00	2,864,628.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,728,000.00	2,728,000.00
35440	Түлш, шатах тослох материал	6,140,000.00	11,752,000.00
35450	Барилгын засварын материал	500,000.00	500,000.00
35460	Хүнсний материал	6,261,140.00	3,075,290.00
35470	Бусад хангамжийн материал	27,310,847.92	39,458,067.92
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	2,180,471,223.24	2,096,391,007.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,180,471,223.24	2,096,391,007.57
39200	Биет хөрөнгө	2,144,998,223.24	2,060,993,007.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,138,975,579.83	2,129,502,919.83
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(154,426,247.19)	(203,663,354.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(3,833,333.51)	(4,333,333.55)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	148,752,108.60	109,079,089.80
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(86,069,879.16)	(56,347,195.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	123,150,756.90	107,549,543.40
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(58,995,963.51)	(53,917,962.93)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,904,500.00	20,834,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(4,144,899.96)	(8,396,799.96)
39217	Номын фонд	15,685,601.24	15,685,601.24
39300	Биет бус хөрөнгө	35,473,000.00	35,398,000.00
39301	Програм хангамж	890,000.00	890,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(665,000.00)	(740,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,248,000.00	35,248,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,230,388,139.16	2,160,930,793.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,230,388,139.16	2,160,930,793.49
51	Засгийн газрын хувь оролцоо	2,230,388,139.16	2,160,930,793.49
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	424,421,939.24	424,421,939.24
51200	Хуримтлагдсан үр дүн	1,389,940,041.54	1,320,482,695.87
51210	Өмнөх үеийн үр дүн	1,389,940,041.54	1,389,940,041.54
51220	Тайлант үеийн үр дүн	-	(69,457,345.67)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	416,026,158.38	416,026,158.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	2,230,388,139.16	2,160,930,793.49



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	805,272,482.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	27,717,129.20
1200	Нийтлэг татварын бус орлого	-	27,717,129.20
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	17,646,009.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	10,071,120.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	777,555,353.00
1310	Улсын төсвөөс	-	731,602,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	731,602,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,452,753.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	-	4,452,753.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	41,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	41,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	-	874,729,827.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	874,729,827.87
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	827,782,025.09
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	-	580,147,785.22
210101	Үндсэн цалин	-	494,843,952.22
210104	Урамшуулал	-	43,979,930.00
210105	Гэрээт ажлын цалин	-	41,323,903.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	80,146,716.00
210201	Тэтгэврийн даатгал	-	58,113,160.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,376,143.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4,458,228.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,129,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	11,069,385.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	34,240,502.00
210301	Гэрэл, цахилгаан	-	6,872,502.00
210302	Түлш, халаалт	-	27,368,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,787,660.00
210401	Бичиг хэрэг	-	822,560.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,862,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	337,500.00
210404	Ном, хэвлэл	-	268,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,401,100.00
2105	Нормативт зардал	-	19,539,980.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,039,900.00
210502	Хоол, хүнс	-	16,822,080.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	678,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,499,300.00
210604	Урсгал засвар	-	1,499,300.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,010,000.00
210702	Дотоод албан томилолт	-	1,010,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	309,857.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	309,857.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	104,100,224.87
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,029,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	-	103,071,224.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	46,947,802.78
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	148,231.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	148,198.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	33.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	22,910,351.78
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,910,351.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	23,889,220.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	18,875,220.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,014,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	-	(69,457,345.67)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	-	(69,457,345.67)



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
8	ҮЛДЭГДЭЛ	424,421,939.24	416,026,158.38	1,389,940,041.54	-	2,230,388,139.16
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	424,421,939.24	416,026,158.38	1,389,940,041.54	-	2,230,388,139.16
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	(69,457,345.67)	-	(69,457,345.67)
16	ҮЛДЭГДЭЛ	424,421,939.24	416,026,158.38	1,320,482,695.87	-	2,160,930,793.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	-	777,555,353.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	777,555,353.00
1310	Улсын төсвөөс	-	731,602,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	731,602,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,452,753.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	-	4,452,753.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	41,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	41,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	-	777,555,353.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	777,555,353.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	734,286,470.22
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	-	580,147,785.22
210101	Үндсэн цалин	-	494,843,952.22
210104	Урамшуулал	-	43,979,930.00
210105	Гэрээт ажлын цалин	-	41,323,903.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	80,146,716.00
210201	Тэтгэврийн даатгал	-	58,113,160.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,376,143.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4,458,228.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,129,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	11,069,385.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	39,852,502.00
210301	Гэрэл, цахилгаан	-	6,872,502.00
210302	Түлш, халаалт	-	32,980,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,213,160.00
210401	Бичиг хэрэг	-	650,060.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,862,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	337,500.00
210404	Ном, хэвлэл	-	268,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,999,100.00
2105	Нормативт зардал	-	19,955,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,039,900.00
210502	Хоол, хүнс	-	17,315,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,979,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	480,000.00
210604	Урсгал засвар	-	1,499,300.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,010,000.00
210702	Дотоод албан томилолт	-	1,010,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	309,857.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	309,857.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,672,100.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,672,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	43,268,882.78
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	148,231.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	148,198.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	33.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	22,910,351.78
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,910,351.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	20,210,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	15,196,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,014,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	-
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	773,102,600.00	750,044,050.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	773,102,600.00	750,044,050.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	752,161,700.00	730,047,750.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	594,559,600.00	580,147,785.22
210101	Үндсэн цалин	505,820,700.00	494,843,952.22
210102	Нэмэгдэл	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	47,258,900.00	43,979,930.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,480,000.00	41,323,903.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,300,800.00	80,146,716.00
210201	Тэтгэврийн даатгал	61,699,300.00	58,113,160.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,495,500.00	5,376,143.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,675,400.00	4,458,228.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,129,800.00	1,129,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,300,800.00	11,069,385.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,000,000.00	39,852,502.00
210301	Гэрэл, цахилгаан	7,000,000.00	6,872,502.00
210302	Түлш, халаалт	33,000,000.00	32,980,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,454,000.00	5,395,540.00
210401	Бичиг хэрэг	500,000.00	497,340.00
210402	Тээвэр, шатахуун	2,208,000.00	2,197,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,000.00	337,500.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	268,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,999,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	22,276,300.00	19,955,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,040,000.00	2,039,900.00
210502	Хоол, хүнс	19,632,700.00	17,315,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	603,600.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,980,000.00	1,979,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	480,000.00	480,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,499,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,850,000.00	1,010,000.00
210702	Дотоод албан томилолт	1,850,000.00	1,010,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	490,000.00	309,857.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	490,000.00	309,857.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,251,000.00	1,251,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,251,000.00	1,251,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,940,900.00	19,996,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,940,900.00	19,996,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,140,900.00	15,196,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	4,800,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4,452,720.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	4,452,720.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4,452,720.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	152,720.00
210401	Бичиг хэрэг	-	152,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	4,452,753.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,452,753.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,452,753.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шилэн баланс аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадалд суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 12 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 885.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 14.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 874.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1 хувиар буюу 69.7 сая төгрөгөөр

буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48.0 сая төгрөгөөс 14.6 сая төгрөгөөр өссөн нь түлш, шатах тослох материал, бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 78.3 сая төгрөг, үнэ төлбөргүйгээр 10.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 72.5 сая төгрөгийн материалыг зарцуулж, Сумын онцгой комисст 1.2 сая төгрөгийн материал шилжүүлсэн бараа материалын эцсийн үлдэгдэл 62.6 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,488.6 сая төгрөгөөс 64.8 сая төгрөгөөр буурсан нь 1.3 сая төгрөгийн хөрөнгө худалдаж авч, 11.2 сая төгрөгийн хөрөнгө хандиваар, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг дахин үнэлэн 6.4 сая төгрөг, аймгийн ИТХ-ын тогтоолоор 60.4 сая төгрөгийн тавилга, машин тоног төхөөрөмжийг акталж, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоохоор 23.4 сая төгрөг хөрөнгө хасагдсан ба үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,423.7 сая төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,160.6 сая төгрөгөөс 8.2 сая төгрөгөөр буусан нь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,320.2 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 942.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 169.6 сая төгрөгөөр бууруулж, 773.1 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 773.1 сая төгрөгийн төсөв баталснаас 731.6 сая төгрөгийг улсын төсвөөс 41.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 731.6 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 41.5 сая төгрөг нийт 773.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 750.1 сая төгрөгийг зарцуулж 22.9 сая төгрөгийг улсын төсөвт, 0.1 сая төгрөгийн орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 750.1 сая төгрөг буюу 97 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 14.4 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.2 сая төгрөгөөр, нормативд зардлыг 2.3 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 0.8 сая төгрөгөөр бараа үйлчилгээний зардал 0.8 сая төгрөгөөр бусад урсгал шилжүүлэг 0.4 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 4.5 сая төгрөгийн гүйлгээ хийгдэн, 0.2 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардал, 4.3 сая төгрөгийг Бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 144 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 4 мэдээлэл, мэдээлэлгүй 2 мэдээлэл байна. 2021 оны 810.7 сая төгрөгийн 17 мэдээллийг ил тод байршуулахаас 810.7 сая төгрөгийн 17 мэдээллийг байршуулж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус

бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 1.4 сая төгрөгийн И-баримтгүй худалдан авалт хийсэн, төрийн сан хяналт тавиагүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."-д гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, Санхүү төрийн сангийн хэлтэст 35.4 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн жилийн аудитаар:

- И-баримтын бүрдэл хангалтгүй төрийн сангаар гүйлгээ хийсэн
- Шатахууны зарцуулалт, тооцоо бодолт
- Орон нутгийн өмчийн газартай уялдаа холбоотой ажилласан байдал
- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Байрны хүүхдийн хоол, үдийн цайны зарцуулалт норм норматив тооцоолол
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 136.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 65.5 сая төгрөгийн алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 70.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Тус сургууль 2009 онд хичээлийн байрны А, Б корпуст хийгдсэн барилгын их засвар 65.2 сая төгрөгөөр барилгын капиталжуулж бүртгээгүй, нэг барилгыг данснаас аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дүн зөрүүтэй тогтоолоор данснаас хассаныг аудитын явцад залруулсан.

Бараа материалын дансанд үнэ төлбөргүй хүлээн авсан 274.5 мянган төгрөгийн материалыг орлогоор залруулав

4.2 Төлбөрийн акт

Ажилтанд үр дүнгийн урамшууллыг 0.2 сая төгрөгийг дутуу, 0.04 сая төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны

тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" заалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Аймгийн ИТХ-ын 83 тоот тогтоолоор 65.2 сая төгрөгийн өртөгтэй, 16.3 сая төгрөгийн элэгдэлтэй хөрөнгийг тогтоол гарсан боловч, уг барилга нь 2009 онд барилгын их засвар хийгдсэн боловч барилгын өртөгт капиталжуулаагүй, үндсэн хөрөнгөд барилгын их засвар гэсэн бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх"-д оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 826.9 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасах хөрөнгийн нэр үнийн дүн зөрүүтэй байна нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл, 77.2.1 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах"-д оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд 1.4 сая төгрөгийн И-баримтгүй худалдан авалт хийсэн, төрийн сан хяналт тавиагүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."-д оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсөвт зардлыг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах"-д оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.4 сая төгрөгийн илүү, 0.2 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тээвэр шатахуун зардалд 2.1 сая төгрөгийн тооцоолол хийгээгүй, спидометрийн заалтгүй, хийгдсэн ажил нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"-д оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийн Акт, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан боловч 1,9 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тээвэр шатахуунд тооцоолол хийгээгүй зөрчлийг давтан гаргасан тул нь Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заасантай нийцэж байгаа тул нягтлан бодогчид сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Тайлангийн үед зөвлөмж өгөгдөөгүй байна

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/											
д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль	10	136.2	2	65.5	1	0.2	7	70.4		
	Дүн	10	136.2	2	65.5	1	0.2	7	70.4		